

6. БҮТЭЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

6.1. Мэдээлэл харилцааны технологийг амьдралд бүтээлчээр ашиглах, программчлалын болон мэдээллийн технологийг ашиглан бүтээл хийх, практик асуудлыг шийдвэрлэх, сурагчдын бүтээлч сэтгэлгээний хөгжлийг дэмжихэд бүтээлийн уралдааны зорилго оршино.

6.2. Бүтээлийн уралдаанд ЕБС-ийн сурагч эсвэл сурагчд баг оролцоно. Баг нь 3 хүртэлх сурагчаас бүрдсэн байна.

6.3. Ашиглах технологи нь программчлалын бүх төрлийн хэл, нээлттэй эх бүхий программ хангамж байж ба хэрэгжлэж буй технологи, программ хангамж нь зохиогчийн эрхийн зөрчилгүй байна.

6.4. Уралдаанд ирүүлэх бүтээлийн чиглэл нь:

6.4.1. Веб сайт

6.4.2. Мультимедиа контент

6.4.3. Программчлалын бүтээл

6.4.4. Гар утасны аппликэйшн

6.4.5. Ухаалаг төхөөрөмж, эмбэддэд программчлал (Arduino, Raspberry pi...)

6.4.6. МХТ ашиглан бүтээсэн бусад бүтээл байна.

6.5. Бүтээлд дараах шаардлага тавигдана. Үүнд:

6.5.1. Зохиогчийн эрхийн зөрчилгүй бүтээл байх (Зөрчилгүй болохыг сурагч болон удирдсан багш баталгаажуулан мэдэгдэл бичсэн байх)

6.5.2. Өмнө нь ямар уралдаан оролцоогүй байх

6.5.3. Шийдлийн оновчтой байдал, судалгааны цар хүрээ

6.5.4. Шинэлэг тал, практик ач холбогдол

6.5.5. Бүтээлийн бүрэн ажиллагаа

6.5.6. Бүтээлийн үр дүн, практик хэрэглээ, туршсан үр дүн

6.6. Бүтээлийн уралдааныг дараах байдлаар зохион байгуулна.

6.6.1. Бүтээлийн танилцуулгыг цахим болон хэвлэмэл хэлбэрээр бэлтгэсэн байна.

6.6.2. Бүтээлийг мэдээлэл зүйн улсын олимпиадын оролцогч болон сонирхогчдод нээлттэй танилцуулж, тэдэнд хэрэглэх боломж олгоно.

6.6.3. Бүтээлийн танилцуулгыг мэдээлэл зүйн улсын олимпиадын бүтээлийн уралдааны комисст 10 минутад багтаан хийнэ.

6.6.4. Бүтээл бүр дэх асуулт, хариултын хугацаа 5 минут байна.

6.7. Бүтээлийг 1 дугаар байр 1, 2 дугаар байр 1, 3 дугаар байр 1, тусгай шагналд 3 хүртэл бүтээлийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулах ба

шагналыг улсын мэдээлэл зүйн олимпиадын шагнал гардуулах ёслолын ажиллагаан дээр гардуулна.

6.8. Бүтээлийн уралдаанд оролцогч нь бүртгэлийн хураамж төлөх ба хураамжийг мэдээлэл зүйн олимпиадын дэд хороо тогтооно.